



**ЭРЧИМ ХҮЧНИЙ
ЗОХИЦУУЛАХ ХОРОО**

2020 оны 04 дүгээр сарын 15

**ОФФИСЫН ТАВИЛГА НИЙЛҮҮЛЭХ
ҮНИЙН САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ**

Төслийн нэр: Оффисын тавилга нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах

**Харьцуулалт/
Гэрээний дугаар: ЭХЗХ/202002003**

**Улаанбаатар хот
2020 он**

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

“Эрчим хүчний зохицуулах хороо” нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **оффисын тавилга** нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Энэхүү тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул **www.tender.gov.mn** хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 20000 (хорин мянган) төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Үнийн саналыг **2020 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 10:00** цагаас өмнө системд ирүүлэх.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2020 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 10:30 цагт** нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх: **Эрхгүй.**

Дотоодын давуу эрх: **Тооцохгүй.**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Монгол улс, Улаанбаатар хот, Их сургуулийн гудамж 2а,
Эрчим хүчний зохицуулах хороо, 3 давхар 303 тоот,
ТЗХГ-н мэргэжилтэн Б.Отгонжаргал
Утас: 319219-110, 99090028**

ХОЁР. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1.Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**
- 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2.Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
- 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
- 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
- 2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3.Тендерийн иж бүрдэл**
- 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
- (а) Үнийн санал;
 - (б) Үнийн боло нийлүүлэлтийн хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4.Тогтмол үнэ**
- 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 5.Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**
- 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
- 5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
- 6.Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
- 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.

**8. Гэрээ
байгуулах эрх
олгох тухай
мэдэгдэл**

- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

ГУРАВ. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<ol style="list-style-type: none"> 1. Өгөгдсөн барааны нэр төрөл болон тоо хэмжээний дагуу гаргасан үнийн санал, Бараа бүтээгдэхүүний чанарыг чухалчилж үзнэ. 2. Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар 3. Сүүлийн 2 жилийн буюу 2018, 2019 оны жилийн эцсийн аудитаар баталгаажуулсан Санхүүгийн тайлан ирүүлэх ба 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан цахим бүртгэлд шивэгдсэн байх. 4. НӨАТ төлөгчийн гэрчилгээний хуулбар 5. Татварын өргүйг нотлох тодорхойлолт 6. Сүүлийн 2 жилийн хугацаанд гүйцэтгэж байсан ажлын туршлагын мэдээлэл/ гэрээгээр гүйцэтгэсэн ажлын хуулбар/ 7. Санал болгож буй бараа нь техник үзүүлэлтүүд нь шаардлагад нийцсэн байх. 8. Барааг захиалагчийн заасан цэгт угсарч суурьлуулах 9. Санал болгож буй барааны фото зураг болон дэлгэрэнгүй танилцуулга ирүүлэх 10. Тендерт оролцогчийн ирүүлсэн саналыг олон нийтэд мэдээлэхэд татгалзах зүйлгүй тухай тендерт оролцогчийн албан мэдүүлэг 11. Олон улсын чанарын стандартын шаардлага хангасан эсэхийг гэрчлэх холбогдох баримт бичгийг хавсарган ирүүлэх. 12. Техникийн шаардлага заалт бүрийг зөвшөөрч хангаж буй тухай албан мэдэгдэл ирүүлэх. 13. Барааны баталгаат хугацаа 1 жил ба түүнээс дээш байх
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Огноо: 2020 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр 10:00 цаг.</p> <p>Цахим тендерийн урилгад заасан тендер хүлээн авах эцсийн хугацаа нь цахим системийн серверийн цагаар тооцогдох бөгөөд хугацаа хоцорсон тендерийг хүлээж авахгүй.</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Их сургуулийн гудамж 2а, Эрчим хүчний зохицуулах хорооны байр,</p> <p>Давхар болон ерөөний дугаар: 4 дүгээр давхар, Хурлын танхимд нээнэ.</p> <p>Огноо: 2020 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр</p> <p>Цаг: 10:30 цаг</p>
ТӨӨЗ 6.1	<p>Тендерт оролцогч нь тендерийн иж бүрдэл, баримт бичгийг бэлтгэн электрон хэлбэрт (Adobe PDF) шилжүүлж цахим хэлбэрээр ирүүлнэ.</p> <p>Оффисын тавилга нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ЭХЗХ/202002003</p>

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. Барааны тодорхойлолт:

Д/д	Нэр	ҮЗҮҮЛЭЛТ
1	Дарга ширээ	Г хэлбэрийн дарга ширээ. Цагаан шаргал өнгөтэй гялгар мебел. 1800x900 мм Ширээнээс залгаа хажуу талдаа шүүгээтэй. Шүүгээний нэг хэсэг гүйдэг хаалгатай дотроо 2 тасалгаатай, нөгөө хэсэг нь түгжээтэй 3 шургуулгатай байх урт 1200x 400мм
2	Хананы шүүгээ	2000x2000x400 мм. Ширээтэйгээ ижил цагаан шаргал өнгөтэй гялгар мебел. Нийт шүүгээ 5 хэсэгтэй байх. Дээд 3 хаалга шилэн түгжээтэй дотроо 3 тасалгаатай, доод 5 хаалга модон түгжээтэй хаалгатай дотроо 2 тасалгаатай. Дээд 2 хаалга модон түгжээтэй байх хувцасны өлгүүртэй байх.
3	Дарга ширээ	1600x800 мм. Бор хүрэн өнгөтэй модон ширээн доороо шүүгээтэй.Шүүгээ түгээжээтэй 3 шургуулгатай байх. Шургуулганы бариул загварлаг төмөр байх
4	Дарга сандал	Дугуйгүй, хүрэн бор арьсан байх. Нүрууны хамгаалалтай өргөн тухтай байх.
5	Дарга сандал	Дугуйтай,цайвар саарал өнгөтэй, өндөр нам тохируулдаг. 360градус эргэдэг, түшлэг нь хэвтдэг зөөлөн,Хажуу талын гар тавих түшлэг битүү арьсан. Сандлын дугуй тогтооч төмөр бэхэлгээтэй байх
6	Бичгийн ширээ шүүгээтэй хаалттай	1600x1600x800x600x720мм Г хэлбэрийн цайвар өнгийн ширээ доороо шүүгээтэй байх.Шүүгээ түгжээтэй 3 шургуулгатай байх. Хаалт 1200 мм өндөртэй 3 талдаа хаалттай байх.
7	Дугуйтай сандал	Дугуйтай, цагаан саарал өнгөтэй, өндөр нам тохируулдаг 360градус эргэдэг. Түшлэг нь хэвтдэг зөөлөн. Толгойн түшлэгтэй, дугуй тогтооч төмөр бэхэлгээтэй байх
8	Бичгийн ширээний хаалт	Ширээний хаалт 3 талтай төмөр болон шилэн раммнаас бүтсэн газраас 1200мм
9	Дарга ширээнд залгаа ширээ	Улаан хүрэн өнгөтэй модон хээтэй байх голдоо нэг хөлтэй. 1200x1200 мм байх.
10	Арьсан сандал дугуйгүй	Дугуйгүй. Улаан хүрэн өнгөтэй арьсан хажуу талын түшлэг мебель байх

2. Стандарт: Тухайн барааны гарал үүсэл нь зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно.

3. **Баглаа, боодол:** Барааны сав баглаа боодол нь шороо, тоосноос хамгаалсан битүүмжлэлтэй байх, барааг хүлээлгэн өгөхдөө бараа хүлээлцсэн баримт, тухайн барааны зарлагын баримт, төлбөрийн нэхэмжлэхийн хамт өгнө.
4. **Бараа хүргэх газар:** 14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Их сургуулийн гудамж 2а
5. **Бараа нийлүүлэлтийн хуваарь:**

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
				Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
Дарга ширээ	1	ш	14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Их сургуулийн гудамж 2а байранд	Гэрээ байгуулагдсанаас хойш 5 хоногийн дотор нийлүүлэх	Гэрээ байгуулагдснаас хойш 5 хоногийн дотор нийлүүлэх	
Хананы шүүгээ	1	ш				
Дарга ширээ	1	ш				
Дарга сандал дугуйгүй	1	ш				
Дарга сандал дугуйтай	1	ш				
Бичгийн ширээ шүүгээтэй хаалттай	10	ш				
Дугуйтай сандал	20	ш				
Бичгийн ширээний хаалт	10	ш				
Залгаа ширээ	1	ш				
Арьсан сандал дугуйгүй	2	ш				

ДӨРӨВ. ЖИШИГ МАЯГТ

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

Огноо:

Эрчим хүчний зохицуулах хорооны дарга А.Тлейхан танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

ТАВ. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | | |
|--|-------|--|
| 1. Шалгах болон турших | 1.1. | Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. | Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. | Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. | Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томьёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. | Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа 1 жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. | Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. | Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ГТН-д заасан тоо] хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. | Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. | Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүй -гээс гэрээг цуцлах | 10.1. | Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |

11. **Маргааныг шийдвэрлэх** 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

ЗУРГАА. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. **Шалгах болон турших (ГЕН – 1)** 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]
2. **Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)** 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
 - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
 - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
 - 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
 - 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
3. **Баталгаат засвар (ГЕН-5)** 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
- [Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]
4. **Төлбөр (ГЕН – 7)** 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
- Нийлүүлэгч бараа материалыг урьдчилгаа төлбөр болох 70%-иар бэлтгэн нийлүүлнэ.
Захиалагч нь бараа материалыг хүлээн авснаас хойш 30%-ийн төлбөрийг хийж, үлдэгдлийн 3 хоногт багтаан нийлүүлэгчийн дансанд шилжүүлнэ.
5. **Алданги оногдуулах (ГЕН - 9)¹** 9.1. Алданги оногдуулах хувь: **0,5%**
- Алдангийн нийт дүн: **50%-аас хэтрэхгүй**

¹ Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

ДОЛОО. ГЭРЭЭНИЙ МАЯГТ

БАТЛАВ

ЗАХИАЛАГЧ	НИЙЛҮҮЛЭГЧ
Эрчим хүчний зохицуулах хороо	_____ ХХК
(Тамга, тэмдэг)	(Тамга, тэмдэг)
_____	_____
(А.Тлейхан)	(Гарын үсэг)
_____	_____
(Хороон дарга)	(Албан тушаал)

Фитнесийн тоног төхөөрөмж нийлүүлэх гэрээ.

Дугаар №

Улаанбаатар хот

Нэг талаас..... (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас(цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож ... оны ... сарын ...ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь (цаашид “бараа” гэх)/...../төгрөгөөр (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын ____-наас _____ оны __ дугаар сарын ____-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:
 - Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
 - Бусад шаардлагатай баримт бичиг²;
 - Үнийн санал;

² Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Албан тушаал, нэр]

*[Гарын үсэг]*_____

*[Гарын үсэг]*_____

ТАМГА

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]